



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/334

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Сургуулийн бакалаврын
орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх
журам шинэчлэх батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 8.1 дэх заалт, МУИС-ийн дүрмийн 4.5.8.3 дахь заалт, МУИС-ийн захиргааны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Их Сургуулийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Оюутан элсүүлэх ажлыг энэхүү журмын дагуу зохион байгуулах, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сургалтын нэгдсэн алба (Ч.Ундрэм), Мэдээллийн технологийн алба (А.Баатарбилэг), бүрэлдэхүүн сургуулийн захирал, сургалтын албаны эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Монгол Улсын Их Сургуулийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт 2015 онд оюутан элсүүлэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Р.БАТ-ЭРДЭНЭ

Захирлын 2015 оны дүгээр сарын-ний
өдрийн дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ОРОЙ, ЭЧНЭЭ ХӨТӨЛБӨРТ ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Монгол Улсын Их Сургууль (цаашид МУИС гэнэ)-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт суралцагч элсүүлэхэд БШУ-ны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам” болон энэхүү журмыг баримтална.
- 1.2. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт бүртгэх, элсэлтийн шалгалт авах болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.3. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “бүртгүүлэгч”, зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийн цахим бүртгэлийн системийг “бүртгэлийн систем” гэнэ. Элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг “элсэлтийн комисс”, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг “комиссын гишүүн” гэнэ.

Хоёр. Элсэлтийн комисс

- 2.1. Элсэлтийн үйл ажиллагааг төв болон салбар комисс хариуцан зохион байгуулна.
- 2.2. Элсэлтийн төв комиссын даргаар сургалт эрхэлсэн дэд захирал, нарийн бичгийн даргаар сургалтын нэгдсэн албаны дарга, гишүүнээр бүрэлдэхүүн сургуулийн захирал, мэдээллийн технологийн албаны дарга, сургалтын нэгдсэн албаны сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, элсэлт, төгсөлт, бүртгэл хариуцсан мэргэжилтэн, салбар комиссын даргаар бүрэлдэхүүн сургуулийн захирал, нарийн бичгийн даргаар сургалтын албаны эрхлэгч, гишүүнээр бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал, тэнхим/нэгжийн эрхлэгч, элсэлт, төгсөлт, бүртгэл хариуцсан мэргэжилтэн ажиллана.
- 2.3. Төв комисс элсэлтийн ажлыг удирдамжаар хангаж, салбар комиссын үйл ажиллагаанд хяналт тавина.
- 2.4. Салбар комисс элсэлтийн шалгалтын материал боловсруулах, шалгалт авах, дүгнэх, дүнг мэдэгдэх, системд оруулах ажлыг хариуцна.
- 2.5. Энэхүү журамд тусаагүй онцгой асуудал гарсан тохиолдолд элсэлтийн төв комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Гурав. Элсэлтийн бүртгэл

- 3.1. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт бакалаврын зэрэгтэй иргэнийг элсүүлнэ (хөтөлбөрийн нэрийг хүснэгт 1, 2-д заасан болно).
- 3.2. Элсэлтийн бүртгэлийг дараах хуваарийн дагуу зөвхөн цахим хэлбэрээр хийнэ.

Үүнд:

- Оройн хөтөлбөрийн бүртгэл: 06 дугаар сарын 01-нээс 08 дугаар сарын 21-ний өдрийг дуустал;

- Эчнээ хөтөлбөрийн бүртгэл: 09 дүгээр сарын 01-нээс 09 дүгээр сарын 21-ний өдрийг дуустал;
- Завхан сургуулийн хувьд эчнээ хөтөлбөрийн бүртгэл: 09 дүгээр сарын 01-нээс 09 дүгээр сарын 21-ний өдрийг дуустал, 02 дугаар сарын 10-наас 03 дугаар сарын 03-ны өдрийг дуустал.

3.3. Хичээлийн жил бүр элсэлт авах хөтөлбөр, шалгалтын нэр, шалгалтын хэлбэр, огноо, хяналтын тоог салбар комиссын саналыг үндэслэн төв комисс шийдвэрлэж бүртгэл эхлэхээс нэг сарын өмнө <http://num.edu.mn>, <http://burtgel.num.edu.mn> хаягаар зарлана.

3.4. Бүртгүүлэгч элсэх хүсэлтээ гаргахдаа бүртгэлийн системд хувийн болон системийн шаардсан бусад мэдээлэл (цахим шуудангийн хаяг, нэвтрэх үг)-ийг зааврын дагуу оруулна.

3.5. Бүртгүүлэгч нь бүртгэлийн систем дэх анкетыг бөглөж, дараах бичиг баримтын эх хувийн хуулбарыг оруулна. Үүнд:

- Өмнө нь эзэмшсэн бакалаврын боловсролын диплом, түүний хавсралт
- Иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг
- Цээж зураг (Зургийн шаардлагыг бүртгэлийн системээс үзнэ үү)

3.6. Элсэлтийн бүртгэлийн хураамжийг хичээлийн жил бүрийн захирлын тушаалаар батлагдсан “Сургалтын үйлчилгээтэй холбоотой хураамжийн үнэлгээ”-нд заасны дагуу авна.

3.7. Бүртгүүлэгч хэдэн ч хөтөлбөрт бүртгүүлэн шалгуулж болох ба элсэлтийн шалгалтандаа тэнцсэн зөвхөн нэг хөтөлбөрт суралцах эрх авна.

3.8. Бүртгүүлэхийг хүссэн хөтөлбөрийг сонгосон үед төлбөл зохих төлбөрийн хэмжээ гарах бөгөөд уг мэдээлэлтэй танилцаж, төлбөрийг цахим хэлбэрээр хийснээр бүртгэл баталгаажна.

3.9. Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

Дөрөв. Элсэлтийн шалгалт

4.1. Бүртгүүлэгч нь элсэхийг хүссэн хөтөлбөрт харгалзах элсэлтийн шалгалт өгнө.

4.2. Элсэлтийн шалгалтыг тест болон бусад хэлбэрээр авна.

4.3. Шалгалт авах өдөр, цаг, хэлбэрийн тухай мэдээллийг шалгалт авахаас 7 хоногийн өмнө <http://burtgel.num.edu.mn> бүртгэлийн системд байршуулж, МУИС-ийн цахим хуудсаар мэдэгдэнэ.

4.4. Шалгалтанд авбал зохих нийт онооны 60-аас доошгүй хувийг авбал МУИС-д элсэх болзол хангасан гэж үзнэ. Шалгалтанд авсан нийт оноог дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- Тухайн хөтөлбөрийн хувьд нэг шалгалт авсан бол уг шалгалтанд авсан оноо;
- Тухайн хөтөлбөрийн хувьд хоёр шалгалт авах бол хоёр шалгалтын оноог 70:30 харьцаагаар тооцно. Өөрөөр хэлбэл, I шалгалтад авсан оноог 0.7-оор, II шалгалтад авсан оноог 0.3-аар үржүүлж нийлбэрээр нь нийт оноог гаргана.

Тав. Элсэх эрх олгох

5.1. Шалгуулагчдыг шалгалтанд авсан нийт оноогоор (4.4-д заасан аргачлалаар тодорхойлж) нь жагсааж, онооны дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ. Оноо тэнцсэн тохиолдолд өмнө эзэмшсэн бакалаврын зэргийн дипломын голч дүнг харгалзана.

5.2. Хяналтын тоонд багтсан эсэхийг шалгалт дууссаны дараа шалгуулагчид мэдэгдэнэ.

5.3. Хяналтын тоонд багтсан тухай мэдэгдэл авсан элсэгч дараах материалыг битүүмжлэл сайтай хавтсанд хийж заасан хугацаанд бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд өгнө. Үүнд:

а. Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг, хуулбарын (ар, өвөр тал нэг нүүрэнд) хамт

б. Өмнө нь эзэмшсэн боловсролын диплом, хавсралт хуулбарын хамт (эх хувиар)

в. Цээж зураг 2 хувь, оюутны үнэмлэхний шаардлагад нийцсэн цээж зураг файл хэлбэрээр (аль аль нь сүүлийн 3 сард авахуулсан)

5.4. Сургалтын албаны мэргэжилтэн бүртгэлийн мэдээллийг эх бичиг баримтуудтай нь тулгаж баталгаажуулж, суралцах эрхийн бичгийг бэлтгэнэ.

Зургаа. Бусад

6.1. Суралцагчийг зөвхөн нэг хөтөлбөрт элсүүлэх тул салбар комиссууд элсэлтийн тухай шийдвэр гаргах үйл явцыг үүнд нийцүүлэн уялдаа холбоотой зохион байгуулна.

6.2. Тухайн хөтөлбөрт бүртгүүлэгчийн тоо 20-оос бага бол элсэлт авахгүй, бүртгэлийн хураамжийг буцаан олгоно.

6.3. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн бүртгүүлэгчийг МУИС-д элсүүлэхгүй, элссэний дараа энэ зөрчил илэрвэл сургуулиас хасна.

6.4. Хяналтын тоонд багтсан элсэгч нь 5.3-д заасны дагуу бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд бүртгүүлээгүй бол элсэх эрхээсээ татгалзсан гэж үзэж энэхүү журмын 4.4-д заасан болзлыг хангасан дараагийн шалгуулагчид суралцах эрх олгоно.

6.5. Бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн тэнхим, сургалтын албаны саналыг үндэслэн элсэгчийн өмнө нь бакалаврын зэрэг эзэмшихдээ амжилттай судалсан ерөнхий суурийн хичээлээс 36 хүртэл, мэргэжлийн хичээлээс 24 хүртэл багц цагийг тооцож болно.

6.6. Элсэлтийг цахим хэлбэрээр явуулахад зориулсан цахим хуудас нь бүтэн жилийн турш тогтмол ажиллагаатай байж, элсэлтийн талаарх мэдээллээр бүртгүүлэгчдийг хангана.


6.7. Цахим бүртгэл явагдаж байх үед МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөрүүдээ танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, бусад хэлбэрээр зохион байгуулна.



МУИС-ийн бакалаврын оройн хөтөлбөрт оюутан
элсүүлэх хөтөлбөрийн жагсаалт

УХД0072 9104399

Бүрэлдэхүүн сургууль	Хөтөлбөр
Шинжлэх ухааны сургууль	Геологи
	Багш, гадаад хэлний боловсрол
	Түүх
Бизнесийн сургууль	Нягтлан бодох бүртгэл
	Санхүү, банк
	Маркетинг
	Худалдаа
	Аялал жуулчлалын менежмент
Хууль зүйн сургууль	Эрх зүй
Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	Мэдээллийн технологи



МУИС-ийн бакалаврын эчнээ хөтөлбөрт оюутан
элсүүлэх хөтөлбөрийн жагсаалт

Бүрэлдэхүүн сургууль	Хөтөлбөр
Шинжлэх ухааны сургууль	Сэтгүүл зүй
	Улс төр судлал
	Түүх
Бизнесийн сургууль	Нягтлан бодох бүртгэл
	Худалдаа
Хууль зүйн сургууль	Эрх зүй
Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургууль	Цаг уур
	Хүрээлэн буй орчны судлал
	Статистик
Орхон сургууль	Нягтлан бодох бүртгэл
Завхан сургууль	Нягтлан бодох бүртгэл
	Санхүү, банк